

БАГШ БЭЛТГЭДЭГ ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЧАДАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ (МУБИС-ийн жишээн дээр)

Д.Энхцэцэг, дэд профессор, Б.Оюунцэцэг, доктор, Л.Оюунгэрэл, БС

Abstract: In recent times, researchers are generalizing teachers' ability to teach quality lessons. For example, in some countries the word 'ability' includes teaching strategies and techniques but in some countries such as Germany, Japan, and Russia this entails teachers' knowledge and skills.

This article discusses elements of theoretical perspectives that explain teachers' knowledge, skills, ability and teaching approaches together. This will also cover a number of empirical research conducted within institutions that focus on teacher education. Considering Mongolian State University of Education (MSUE) is the leading state university in training of teachers, MSUE has the tradition of continually improving the quality of training and implementing important developments for teachers' education. Training of competent educators is one of the primary goals of university for teachers and accomplishment of this goal is of strategic importance to overall education system. University professors and lecturers with special training have been and always will be the main professionals for the execution of scientific research for the training development. Since we live in society where concepts of 'value of key attributes' and 'education' are changing, the need to discuss about the quality of university lecturers' knowledge and skills arises. For instance, what skills and capabilities should be learnt by the lecturers and professionals during the training of the teachers? How to assess the skills that has been or is being learnt? This is one of the pressing problems that is being faced. Research in this area is much needed. Therefore, following study investigated research papers from internationally trusted sources and conducted analysis and summary of the quality of training for teachers' education.

Түлхүүр үг: Мэдлэг, чадвар, чадавх, чадамж, хандлага, багшийн мэргэжлийн чадамж

Удиртгал

Монгол улсын Боловсролын их сургууль нь багшлах боловсон хүчин бэлтгэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг үндэсний их сургуулийн хувьд багш бэлтгэх, сургалтын чанарыг сайжруулах ажлыг тасралтгүй гүйцэтгэж, багш боловсролын хөгжилд олон чухал ажлыг хэрэгжүүлж ирсэн уламжлалтай билээ.

Чадварлаг багш бэлтгэх нь багш бэлтгэдэг их дээд сургуулиудын чухал зорилтын нэг бөгөөд энэ нь нийт боловсролын системийн хувьд стратегийн ач холбогдолтой. Их дээд сургуулийн профессор багш нар нь сургалт эрдэм шинжилгээний ажлын гол мэргэжилтэн байсан, одоо ч байгаа, цаашдаа ч байх болно.

Бидний амьдарч буй нийгэм, үнэт зүйлийн үнэлэмж, боловсрол гэдэг ухагдахуун хүртэл өөрчлөгдөж байгаа болохоор Их дээд сургуулийн багшийн мэргэжлийн мэдлэг, чадвар чадамж, хандлагын талаар ярих шаардлага зүй ёсоор гарч ирдэг. Тухайлбал: их, дээд сургуулийн багш багшлахуйн явцдаа ямар чадвар, чадамж,

хандлага эзэмших ёстой вэ? Ийм чадвар, чадамж, хандлагатай болсныг нь яаж үнэлэх вэ? гэдэг нь тулгамдсан асуудлын нэг юм. Энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажил үгүйлэгдэж байна.

Иймд энэ чиглэлээр дэлхийн түвшинд хийгдсэн судалгааны материалуудын эх сурвалжийг судалж, анализ, дүгнэлт хийж үзэв.

Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш мэргэжилтний чадвар, чадамж, хандлагын талаар өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг асуулгын аргаар авч нэгтгэн дүгнэсэн нь их, дээд сургуулиудын багш мэргэжилтний чадвар, чадамжийг цаашид эрчимжүүлэн, хөгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэж үзэж байна. / МУБИС-ийн бүрэлдэхүүний сургуулийн 167 багш нараас буюу (37%) -нь оролцсон/.

Мэдлэг, чадвар, чадамжийн тухай онолын зарим асуудал

Багш мэргэжилтэн ямар мэдлэг чадвар чадамжтай байх талаар хийсэн суурь судалгааны дотор 1980-аад оны сүүлээр Харвардын их

сургуулийн Harvart Educational Review сэтгүүлд хэвлэгдсэн эрдэмтэн Шулманы (Lee Shulmann) “Knowledge growth in teaching”, “Knowledge and teaching of the new reform”) гэсэн өгүүлүүд зүй ёсоор ордог. Эрдэмтэн Шулман “Багшийн мэдлэгийг гурван хэсэгт ангилан үзэж, англи хэл дээр “Content knowledge”, “Pedagogical content knowledge”, “Pedagogical knowledge” гэсэн нэр ухагдахуунаар илэрхийлсэн байна.

Бид Европын холбооны эрдэмтдийн суурь судалгааны эх сурвалж дээр ажилласан учир эхлээд нэр томьёо, түүний орчуулгын талаар зарим тайлбарыг хийх нь зүйтэй гэж үзлээ. МУИС, МУБИС-ийн судлаачид эдгээр нэр томьёог монгол хэл дээр хөрвүүлэн хэрэгжүүлж ирсэн уламжлалыг энд мөрдөв. Үүнд:

- Content knowledge-гэсэн ухагдахууны утга санааг герман хэл дээр “Fachwissen”-гэж илэрхийлдэг. Энэ ухагдахууныг мэргэжлийн мэдлэг буюу тухайн шинжлэх ухааны мэдлэг гэж монгол хэлэнд буулгасан. Энэ нь сэтгэл судлалын багш хүний хувьд сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэг гэсэн үг.
- Pedagogical content knowledge-Германаар “Fachdidaktisches Wissen” гэсэн ухагдахууныг мэргэжлийн дидактикийн мэдлэг гэдэг. Энэ нь математикийн багшийн хувьд математикийн хичээл, математикийг сурах ба сургах асуудлыг судалдаг дидактикийн шинжлэх ухааны мэдлэг юм.
- Pedagogical knowledge-гэсэн ухагдахуун нь

сурган хүмүүжүүлэх ухаан буюу сурган – сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэг ч гэж нэрлэдэг.

Мэргэжлийн судалгаа, ном зүйд энэхүү гурван мэдлэгийг СК, РСК, РК гэж тэмдэглэж заншсан байна.

Content knowledge СК-тодорхой мэргэжлийн мэдлэг

Pedagogical knowledge РК-мэргэжлийн дидактикийн мэдлэг

Professional Kompetenz РК –мэргэжлийн цогц чадамж

Багш нар бол боловсролын шинэчлэлийн гол хөдөлгөгч хүч бөгөөд тэд мэргэжлийн өндөр, бүтээмжит чадамжуудыг эзэмшсэн байх шаардлагатайгаас гадна тэдгээрийг хянан шинжлэх хэрэгтэй гэж үздэг юм байна.

Судлаачдын зохиол бүтээлд: “Чадавхи” бол тодорхой нийгэм соёл дах чухал асуудлыг шийдвэрлэхэд үр дүн гаргах чадвар

“Чадамж” бол ур чадвар, мэдлэг, хандлагын цогц нэгдэл

“Багшийн чадамж” (teacher competence)-ийг багшийн ажлыг үр дүнтэй хийж гүйцэтгэхэд шаардагдах ур чадвар, мэдлэг, хандлагын цогц гэж тодорхойлсон байна.

Бид ч энэ багшийн чадамж гэсэн ухагдахууныг уг ойлголтоор авч үзсэн.

Багшийн суурь чанарыг тодорхойлох бүтэцчилсэн хүрээг дараах байдлаар гаргасан байна. /Герман, Финлянд, ОХУ/

Хүснэгт 1

Үндсэн бүлэг	Дэд бүлэг	Дэд бүлэгт харгалзах хэсгүүд
Мэдлэг	1.Академик /онолын мэдлэг/ 2.Мэргэжлийн мэдлэг	-Агуулгын мэдлэг -Дидактик мэдлэг -Сурган хүмүүжүүлэх мэдлэг
Ур чадварууд	1. Багшлахуйн чадварууд 2. Сурган хүмүүжүүлэх чадварууд /дидактик чадварууд/ 3. Менежментийн чадварууд 4. Зохион байгуулах чадварууд 5. Эргэцүүлэх чадварууд 6. Харилцааны чадварууд 7. Нийгэмшихүйн чадварууд	
Хандлага	1.Итгэл үнэмшил 2. Сэдэл 3.Иргэншихүй 4.Мэргэжлийн /өндөр стандартыг хангасан, ур чадвартай хүний /байр суурьнаас хандах байдал	

Хувь хүний чанар	1. Сэтгэлийн хөдөлгөөний тогтворжилт 2. Гадагшаа чиглэсэн 3. Нээлттэй 4. Зөвшилцөхөд бэлэн байдал 5. Ажил үүрэгтэй холбоотой аливаа зүйлд хянуур нямбай хандах байдал	
------------------	---	--

Хүн аливаа мэргэжлийг нарийн сайн эзэмшиж чадвал, мэргэжил нь оюун ухааны бөгөөд олон талт үйл ажиллагааны цогц чадамж болж чадах юм.

Мэдлэг, чадамж гэдэг 2 ойлголтыг нарийн судлах шаардлагатай. Судлаачдын зохиол бүтээлд тухайн мэргэжлийг хамрах хүрээ, хэлбэр түвшингээр нь 4 ангилсан байна.

1. Тухайн мэргэжлийг эзэмших чадавх, боломж хүн бүрд адилгүй байдгаас түүний хөдөлмөрийн бүтээмж нь субъект бүхий үйл ажиллагаа
2. Хөдөлмөрийн үйл ажиллагаагаар нь хүний нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлно
3. Мэдлэг, ур ухааны тусламжтайгаар тухайн хөдөлмөрийн хүрээг тодорхойлно.

Мэргэжлийн эцсийн үр дүнд нь үйл ажиллагааны биелэлтээр тодорхойлогдоно.

Багшлах үйл ажиллагааны мэргэшлийг тодорхойлох асуудал нь сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг, чадвар туршлагыг үнэлэх үнэлэлт мөн. Мэргэших үйл явц нь 3 үндсэн чиглэлээр явагдана.

1. Мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааны шаталсан бүтэц бүхий өөрчлөлт
2. Субъектийн дотоодод гарч буй өөрчлөлт
3. Субъектийг бүрдүүлж буй гишүүдийн бүтцийн өөрчлөлт

Энэхүү өөрчлөлт нь когнитив хүрээнд, мэдээллийн түвшинд явагдах ба

- Сэтгэл хөдлөлийн хүрээ
- Дадлага туршлагын хүрээ
- Субъектийн хүрээнд нөлөөлнө.

Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны дотоод механизмыг судлахад тэдгээрийн биологийн онцлог шинж чанар нь мэргэжлийн төвшний гол суурь тулгуур нь болж өгдөг. Эрдэмтэн В.С Мерлина, Е.Л Климова нарын судалгаагаар дээрх асуудлын суурь тавигджээ.

Судлаач В.В Белоусовагийн хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл: Хүний зан араншингийн төлөвшилийг тодорхойлоход тухайн мэргэжлийн онцлог нөлөөлдөг болох нь харагдсан. Зөвхөн энэ хүрээнд хувь хүний мөн чанар, ажлын үр дүнтэй зохицолддог болохыг гаргаж тавьсан.

Судлаач Б.И. Теплов багшийн мэргэжлийн

үүргээр нь тодорхойлохыг зорьжээ.

“Багшийн мэргэжил хүнд хэцүү хэдий ч багшаас өөрөөс нь шалтгаалдаг” гэж тэрээр үзжээ. Багшлахуй нь багшаас хүүхэдтэй ажиллах үед сэтгэл зүйн тогтвортой байдлаа хадгалах чадвар буюу өөрийгөө хянах чадвараар илрэн гардаг.

Дээрх судалгааны үр дүнд тулгуурлан судлаач Н.А.Аминов багшийн мэргэжлийн мэдрэмжийн үйл ажиллагааг нь илүү хөгжсөн олонх тохиолдолд хүнтэй харилцах харилцаанд амжилт гаргадгийг нотолжээ. Тэрээр “Шинийг санаачлагч багш нарын үйл ажиллагаа”-ны үр дүнгээр тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, багшийн ажиллах чадвар багшаас өөрөө өөрийгөө удирдах онцгой авьяас шаарддаг байна.

Орчин үеийн багш хүн суралцагчдаа бусадтай хамтран ажиллах, тулгарч буй аливаа зорилтыг шийдвэрлэх, сурах арга барил эзэмших, үүнийхээ үр дүнд үнэ хүндтэй иргэн, үнэтэй цэнэтэй мэргэжилтэн болон төлөвшихийн тулд өндөр чадамжтай багш байх учиртай юм.

“Competency for Teache”- багшийн практик үйлийн гол өөрчлөлт болно.

Бид багшийн чадамжийг дараах байдлаар загварчлан авч үзээд, судалгааны үр дүнтэй холбож, тайлбарлах болно.






2.МУБИС-ийн профессор багш нараас авсан судалгааны дүнгээс танилцуулья.

Энэхүү судалгаанд МУБИС-ийн бүрэлдэхүүний 10 сургуулийн 167 профессор багш нар хамрагдлаа. Судалгаанд оролцогчдын Ерөнхий мэдээллийг танилцуулья.

Их дээд сургуульд 1-5 жил-21,6%, 6-10 жил-21%, 11-15 жил-20,4%, 16-аас дээш ажилласан нь 37% байгаагаас харахад түүвэр тохиромжтой байна.

Судалгаанд оролцогчдыг сургууль сургуулиар нь болон төгссөн сургуулиар нь харуулбал:



Судалгаанд оролцогчдын боловсролын зэрэг

Бакалавр	Магистр	Доктор /Ph.D/	Доктор /Sc.D/
-	63.3%	35.5%	0.6%

1. Их сургуулийн профессор багш ямар хэлбэрээр мэргэжил дээшлүүлэх ёстой гэж та бодож байна вэ? Хамгийн чухал гэсэн 2 хариултыг дугуйлна уу.


Эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх	Бие даан	Төлөвл. сургалтад хамрагдах	Төсөл хөтөлбөрт ажиллах	Гадаадын их сургуульд суралцах (ажиллах)
35.4%	6.8%	10.3%	15.6%	31.9%

2. Их сургуулийн багшид байх чадваруудын хамгийн чухлыг нь эрэмбэлэн тохирох дугаарыг тэмдэглэнэ үү.


2-р асуулт	1	2	3	4	5	6	7	8	0
Онолын өндөр мэдлэгтэй	52,0	20,1	11	5,4	3,4	3,4	1,3	3,4	0
Судлан шинжлэх чадвартай	23,4	37,7	14,3	7,8	5,2	2	3,2	5,8	0,6
Суралцагчдын талаарх мэдлэгтэй	8,00	12	26	4	7	13	9	20	1
Багшлахуйн чадвартай	10,1	12,8	20,7	20,7	11,7	10	6,7	6,7	0,6
Өөрийгөө хөгжүүлэх чадвартай	11,7	13,1	11	18,6	15,9	13,8	8,3	6,9	0,7

Харилцааны чадвартай	3,7	7,4	8,1	17	19,3	19,3	12,6	9,6	3
Зөв бодитой үнэлэх чадвартай	0,8	3,1	3,8	7,7	12,3	16,2	28,5	23,8	3,8
Төлөвлөх чадвартай	0,7	3	5,2	14,8	20,7	16,3	23	11,9	4,4


3. Та гадаадын их сургуульд туршлага судлах болон багш солилцоогоор ажиллахад таны гадаад хэлний чадвар хангалттай юу? /ГХС-ийн мэргэжлийн хэлний багш нарын судалгааг оруулаагүйгээр/



4. Та ямар хэлбэрээр мэдлэг, чадамжаа дээшлүүлэх бодолтой байна вэ?



5. Сүүлийн 2 жилд мэргэжлээ дээшлүүлэх чиглэлээр ямар ямар сургалтад хамрагдсан бэ?



он	Англи хэлний сургалт	МХТ	Кембридж, Шинэчилсэн хөтөлбөр	Хэрэглээний боловсрол	Гадаадад мэргэжил дээш.сэн	ТХБ	Бусад	Нийт
2012	4	10	10	0	17	1	27	69
	5,8%	14.5%	14.5%	0%	24.6%	1.4%	39.2%	100%
2013	28	42	8	6	18	1	27	130
	21.5%	32.3%	6.2%	4.6%	13.8%	0.8%	20.8%	100%

ДҮГНЭЛТ

Бидний энэхүү бичил судалгааны дүнгээс авч үзвэл:

1. Багш бэлтгэдэг Их сургуулийн профессор багшийн мэдлэг, чадвар, чадамжийн талаарх судалгаанд МУБИС-ийн бүрэлдэхүүний 10 сургуулийн 167 профессор багш нар хамрагдлаа. Судалгаанд оролцогчдын 21,6% нь 1-5 жил, 21% нь 6-10 жил, 20,4% нь 11-15 жил, 37% нь 16-аас дээш жил ажилласан байна.
2. Судалгаанд оролцогчид Их сургуулийн профессор багш онолын өндөр мэдлэгтэй(52%), Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чадвар(37,7%)-тай байх бөгөөд оролцогч багш нарын 35,4% нь Эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар, 31,9% нь өндөр хөгжилтэй улс орны их дээд сургуульд очиж, туршлага судлах, гадаадын их дээд сургуульд урт богино хугацаагаар суралцах, багш солилцоогоор ажиллах, 15,6% нь төсөл хөтөлбөрт хамрагдах гэх мэт байдлаар мэргэжлээ дээшлүүлэх бодолтой байна. Гэвч 55% нь гадаад хэлний чадвар дунд зэрэг буюу хангалтгүй гэж хариулснаас үзэхэд гадаадын их дээд сургуульд суралцах, багш солилцоогоор ажиллахад хэлний чадвар дутагдаж байгаа нь харагдлаа.
3. Судалгаанд оролцогчид 2012 онд мэргэжил дээшлүүлэх чиглэлээр 65 удаа, 2013 онд 120 удаа сургалтад хамрагдсан нь 45,8%-иар өссөн, 2013 онд англи хэлний эрчимжүүлсэн сургалтад 15,7%, мэдээлэл харилцааны технологийн сургалтад 17,8% өссөн эерэг үзүүлэлтүүд харагдаж байна.
4. Судалгааны дүнгээс харахад цаашид манай багш нар дараах хэлбэрээр мэдлэг, чадамжаа дээшлүүлэх бодолтой байгаа нь ажиглагдав. Үүнд:
 - Гадаад явж туршлага судлах, гадаадын их дээд сургуульд урт богино хугацаагаар суралцах, багш солилцоогоор ажиллах(33,7%)

- Бие дааж өөрийгөө хөгжүүлэх(15,2%)
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар (13%)...
- 5. Судалгааны дүнгээс харахад зарим эерэг өөрчлөлтүүд байгаа боловч багш нар цахим сургууль, ялангуяа өндөр хөгжсөн технологитой орчин бүрдүүлэх асуудлыг салбарын бодлогын хүрээнд авч үзэх нь зүйтэй гэсэн санал ирүүлсэн байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Бэгз, Н. (2011). Боловсролын хөгжлийн чиг хандлага

Жадамбаа, Б. (2012) Багш боловсролын ирээдүй

Лувсандорж, Ц. (2014) 21-р зууны багшийн боловсрол, түүний хөгжлийн чиг хандлага, Багш боловсролын хөгжлийн шинэ хандлага

Монгол Улсын засгийн газрын 2008 оны 316-р тогтоолын 1-р хавсралт. "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр" www.mecs.gov.mn

Монгол Улсын засгийн газрын 2010 оны 31-р тогтоолын хавсралт. "Боловсрол" үндэсний хөтөлбөр (2010-2012 он) www.mecs.gov.mn

Вэб сайт:

www.eric.edu.com www.actionresearch.altec.org

<http://www.unesco.org/en/competency-standard>

<http://azps.ru/articles/tezis/34zadak>

<http://www.psychology.ru/library/p001.stm> <http://progressman.ru/2009/09/skill/>

<http://azps.ru/training/indexcg.html>

Боловсролын инноваци-багш боловсролын шинэчлэл. 2014